



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улиастай сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/157/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: <a href="mailto:Bat-Undraa@audit.gov.mn">Bat-Undraa@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор : Б.Дагвасүрэн Утас:99014227 Цахим хаяг: <a href="mailto:dagvasurenb@audit.gov.mn">dagvasurenb@audit.gov.mn</a></p> <p>Аудитор Б.Жалбаа Утас: 89330330 Цахим хаяг: <a href="mailto:jalbaab@audit.gov.mn">jalbaab@audit.gov.mn</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	13
4. Аудитын илрүүлэлт .....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12

додд. ор. д/ № 1302/60  
төний \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

УЛИАСТАЙ СУМЫН ХҮҮХДИЙН 4 ДҮГЭЭР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Ж.РААШ-Д

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улиастай сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улиастай сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

013020933

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/мян.төг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>43,522.90</b>	<b>47,583.75</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>0.00</b>	<b>47.49</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	47.49
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>43,522.90</b>	<b>47,536.25</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>10,956.48</b>	<b>10,956.48</b>
35110	Тусгай зориулалттай материал	9,738.48	9,738.48
35130	Эм боох материал	1,218.00	1,218.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>32,566.42</b>	<b>36,579.78</b>
35410	Бичиг хэргийн материал	406.22	740.02
35420	Аж ахуйн материал	23,068.31	25,166.06
35440	Түлш, шатах тослох материал	0.00	600.01
35450	Барилгын засварын материал	5,949.50	6,269.50
35460	Хүнсний материал	116.40	210.60
35470	Бусад хангамжийн материал	3,026.00	3,593.60
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>663,880.87</b>	<b>650,122.58</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>663,880.87</b>	<b>650,122.58</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>652,185.87</b>	<b>638,757.58</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	673,481.25	673,481.25
39202	Хуримтлагдсан элэгдэл	-34,552.36	-51,828.55
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	44,662.81	51,889.61
39206	Хуримтлагдсан элэгдэл	-41,013.07	-41,808.87
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,319.64	38,319.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	-29,232.00	-31,815.11
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,227.32	1,227.32
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,227.32	-1,227.32
39217	Ном	519.61	519.61
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>11,695.00</b>	<b>11,365.00</b>
39301	Програм хангамж	1,850.00	1,850.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-255.00	-585.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,100.00	10,100.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>707,403.77</b>	<b>697,706.33</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>1,447.70</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>1,447.70</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>0.00</b>	<b>1,447.70</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	1,447.70
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>707,403.77</b>	<b>696,258.63</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>707,403.77</b>	<b>696,258.63</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	127,012.45	127,012.45
51101	Өмч: - төрийн	127,012.45	127,012.45
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>555,573.22</b>	<b>544,428.09</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	555,573.22	555,573.22
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-11,145.13
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	24,818.10	24,818.10
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>707,403.77</b>	<b>697,706.33</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/мян.төг/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>443,898.58</b>	<b>451,683.22</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,499.00</b>	<b>13,560.22</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,499.00</b>	<b>13,560.22</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,499.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,499.00	0.00
120009	Бусад орлого	0.00	13,560.22
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>440,399.58</b>	<b>438,123.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>382,550.20</b>	<b>0.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	382,550.20	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>49,675.30</b>	<b>41,086.30</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49,675.30	41,086.30
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	8,174.08	0.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>8,174.08</b>	<b>397,036.70</b>
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	397,036.70
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>460,878.26</b>	<b>462,828.35</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>460,878.26</b>	<b>462,828.35</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>432,445.02</b>	<b>444,893.94</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>276,487.78</b>	<b>286,979.79</b>
210101	Үндсэн цалин	276,487.78	179,332.63
210102	Нэмэгдэл	0.00	82,514.36
210104	Урамшуулал	0.00	25,132.80
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>35,635.77</b>	<b>38,499.31</b>
210201	Тэтгэврийн даатгал	24,377.95	27,125.50
210202	Тэтгэмжийн даатгал	2,869.88	2,807.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,238.78	2,331.79
210204	Ажилгүйдлийн даатгал	552.21	571.10
210205	Эрүүл мэндийн даатгал	5,596.96	5,663.11
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>46,788.66</b>	<b>48,289.56</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,466.18	2,300.11
210302	Түлш, халаалт	39,112.38	42,590.25
210303	Цэвэр, бохир ус	5,210.10	3,399.20
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,837.48</b>	<b>6,830.05</b>
210401	Бичиг хэрэг	1,324.55	949.40
210402	Тээвэр, шатахуун	395.00	2,245.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	713.18	484.45

**Улиастай сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитын тайлан**

210404	Ном, хэвлэл	0.00	96.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,404.75	3,054.40
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>39,777.40</b>	<b>33,258.16</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,356.50	2,575.98
210502	Хоол, хүнс	34,740.70	27,785.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,680.20	2,896.88
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,411.30</b>	<b>5,060.00</b>
210604	Урсгал засвар	5,411.30	5,060.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>0.00</b>	<b>1,348.20</b>
210702	Дотоод албан томилолт	0.00	1,348.20
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,472.70</b>	<b>581.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,472.70	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	581.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>23,033.94</b>	<b>24,047.88</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,416.90	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	3,062.80
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,617.04	20,985.08
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>28,433.24</b>	<b>17,934.41</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,874.08</b>	<b>13,560.22</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,874.08	13,560.22
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>20,559.16</b>	<b>4,143.44</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,559.16	4,143.44
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>0.00</b>	<b>230.74</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	230.74
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-16,979.68</b>	<b>-11,145.13</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-16,979.68</b>	<b>-11,145.13</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

СТ-4А

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ мян.төг /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00

**Улиастай сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитын тайлан**

C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00
C08	<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	127,012.45	24,818.10	555,573.22	707,403.77
D01	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	127,012.45	24,818.10	555,573.22	707,403.77
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	127,012.45	24,818.10	555,573.22	707,403.77
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-11,145.13	-11,145.13
D09	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	127,012.45	24,818.10	544,428.09	696,258.63

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

СТ-2А

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>440,399.58</b>	<b>451,683.22</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>13,560.22</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>0.00</b>	<b>13,560.22</b>
120009	Бусад орлого	0.00	13,560.22
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>440,399.58</b>	<b>438,123.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>382,550.20</b>	<b>0.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	382,550.20	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>57,849.38</b>	<b>41,086.30</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49,675.30	41,086.30
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	8,174.08	0.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>0.00</b>	<b>397,036.70</b>
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	397,036.70
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>438,749.58</b>	<b>444,456.42</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>438,749.58</b>	<b>444,456.42</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>410,316.34</b>	<b>426,522.01</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>273,920.95</b>	<b>285,532.10</b>
210101	Үндсэн цалин	186,804.12	180,575.35

Улиастай сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитын тайлан

210102	Нэмэгдэл	66,154.41	82,514.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	633.51	0.00
210104	Урамшуулал	20,328.91	22,442.39
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>38,438.80</b>	<b>38,546.80</b>
210201	Тэтгэврийн даатгал	27,049.50	27,125.50
210202	Тэтгэмжийн даатгал	2,847.30	2,807.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,277.90	2,331.79
210204	Ажилгүйдлийн даатгал	569.50	571.10
210205	Эрүүл мэндийн даатгал	5,694.60	5,710.60
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>49,675.30</b>	<b>48,889.56</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,108.78	2,300.11
210302	Түлш, халаалт	43,726.18	43,220.25
210303	Цэвэр, бохир ус	2,840.35	3,369.20
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,438.68</b>	<b>8,072.41</b>
210401	Бичиг хэрэг	1,281.20	1,281.20
210402	Тээвэр, шатахуун	395.00	2,245.81
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	713.18	800.00
210404	Ном, хэвлэл	96.20	96.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,953.10	3,649.40
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>37,124.71</b>	<b>33,616.36</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,574.50	2,575.98
210502	Хоол, хүнс	32,603.71	27,879.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,946.50	3,160.88
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0.00</b>	<b>5,100.00</b>
210604	Урсгал засвар	0.00	5,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>0.00</b>	<b>1,348.20</b>
210702	Дотоод албан томилолт	0.00	1,348.20
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,660.10</b>	<b>581.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,510.10	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	581.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,057.80</b>	<b>4,835.60</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,057.80	4,835.60
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>28,433.24</b>	<b>17,934.41</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,874.08</b>	<b>13,560.22</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,874.08	13,560.22
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>20,559.16</b>	<b>4,143.44</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,559.16	4,143.44
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>0.00</b>	<b>230.74</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	230.74
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>1,650.00</b>	<b>7,226.80</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,650.00</b>	<b>7,226.80</b>

22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	1,650.00	7,226.80
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	1,650.00	7,226.80
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,650.00	7,226.80
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	-1,650.00	-7,226.80

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ мян.төг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	435,212.90	433,748.81
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	0.00	433,748.81
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.44	0.43
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	285.53	285.53
210101	Үндсэн цалин	197,751.20	180,575.35
210102	Нэмэгдэл	66,144.70	82,514.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	500.00	0.00
210104	Урамшуулал	21,136.20	22,442.39
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38.55	38.55
210201	Тэтгэврийн даатгал	27,125.50	27,125.50
210202	Тэтгэмжийн даатгал	2,855.30	2,807.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,284.30	2,331.79
210204	Ажилгүйдлийн даатгал	571.10	571.10
210205	Эрүүл мэндийн даатгал	5,710.60	5,710.60
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	49.12	48.89
210301	Гэрэл, цахилгаан	2,500.00	2,300.11
210302	Түлш, халаалт	43,220.30	43,220.25
210303	Цэвэр, бохир ус	3,400.00	3,369.20
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8.08	8.07
210401	Бичиг хэрэг	1,281.20	1,281.20
210402	Тээвэр, шатахуун	2,246.00	2,245.81
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800.00	800.00
210404	Ном, хэвлэл	96.10	96.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,653.10	3,649.40
2105	<b>Нормативт зардал</b>	34.47	33.62
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,576.20	2,575.98
210502	Хоол, хүнс	28,731.60	27,879.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,160.90	3,160.88

**Улиастай сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитын тайлан**

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5.10	5.10
210604	Урсгал засвар	5,100.00	5,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1.44	1.35
210702	Дотоод албан томилолт	1,441.40	1,348.20
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	0.86	0.58
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864.80	581.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	12.06	12.06
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,062.40	12,062.40
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	435.21	433.75
131001	Улсын төсвөөс санхүүжих	380,992.60	379,759.26
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	54,220.30	53,989.56

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

НТ-2

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ мян.төг /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>13,560.22</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	13560.22
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13,560.22
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,560.22
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	13560.22
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	13,560.22
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,560.22

**3. Аудитын тайлан**

**3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улиастай сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитор Б.Жалбаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Улиастай сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Улиастай сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг нь “Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагааг явуулж байна

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг бүхий нэгж тус байгууллагад байхгүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улиастай сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлого 451,683.2 мянган төгрөгийн 1 хувь буюу 4,516.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 3,387.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитаар хянаж үзээд дахин өөрчлөх шаардлагагүй гэж үүлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.00	47.50	47.50
Бараа материал	43,522.90	47,536.30	4,013.40
Үндсэн хөрөнгө	663,880.90	650,122.60	-13,758.30
<b>Нийт хөрөнгө</b>	<b>707,403.80</b>	<b>697,706.40</b>	<b>-9,697.40</b>
Өр төлбөр	0.00	1,447.70	1,447.70
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	707,403.70	696,258.60	-11,145.10
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>707,403.70</b>	<b>697,706.30</b>	<b>-9,697.40</b>

Авлага 47.5 мянган төгрөг болж нэмэгдсэн нь Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага шинээр үүссэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 4,013.4 мянган төгрөг болж өссөн нь номыг бараа материалаар бүртгэсэн, хүүхдийн тоглоом худалдан авсан зэрэгтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 697,706.4 мянган төгрөг болж буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл 1,447.7 мянган төгрөг болж өссөн нь татварын өглөг үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 696,258.6 мянган төгрөг болж буурсан нь хуримтлагдсан үр дүн 11,145.1 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Дээд шатны төсөв захирагч тус байгууллагын 2021 оны төсвийн зарлагыг 435,212.9 мянган төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс 380,992.6 мянга, орон нутгийн төсвөөс 54,220.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 379,036.7 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 41,086.3 мянган төгрөгийн, нийт 438,123.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагааны зардалд 433,748.8 мянган төгрөгийг зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 13,560.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн бөгөөд энэ нь дээд шатны төсөв захирагчаас хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа алба хаагчдын мөнгөн урамшуулалд зориулан олгосон санхүүжилт байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын үйл ажиллагаанд онцолж үзэх асуудал байхгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Байгууллагын үйл ажиллагааны зардал болох хүнсний материалыг нийлүүлэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байдлыг санхүүгийн аудитаар шалгахад материаллаг алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 121 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 28 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 81.2 хувьтай байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд НББ-ийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлэн тайлагнаж Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх материаллаг эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

## **4. Аудитын илрүүлэлт**

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар нийт 2.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

#### 4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар залруулах алдаа зөрчил илрээгүй болно.

#### 4.2 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй болно

#### 4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй болно

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

#### 1.1. Илрүүлэлт:

Батлагдсан төсвийг зориулалт бус зарцуулсан 1,293.0 мянган төгрөгийн зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

#### 1.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан “зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын дагуу зарцуулж, тайлагнах

### 2. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой

#### 2.1. Илрүүлэлт:

Харилцагч байгууллага, иргэдээс НӨАТ-ын баримт дутуу авсан 1,233.5 мянган төгрөгийн зөрчил байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 “албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд төлбөр хийсэн тухай бүр бүртгэнэ”, 17.3.2 “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

#### 2.2. Өгсөн зөвлөмж:

Харилцагч байгууллагад төлсөн мөнгөний НӨАТ-ын баримтыг тухай авч нэгдсэн системд бүртгэж байх. Харилцагч байгууллага НӨАТ-ын баримтыг олгоогүй нөхцөлд харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэж баримтыг гаргуулан авах арга хэмжээг авч ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл


/сая төгрөгөөр/

Улиастай сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитын тайлан

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Улиастай сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг	2	2.5					2	2.5		

**БОЛОВСРУУЛСАН:**

АУДИТОР



Б.ЖАЛБАА

**ХЯНАСАН:**

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

АХЛАХ АУДИТОР



Б.ДАГВАСҮРЭН

